

# Living the LOTUS

*Buddhism in Everyday Life*



VOL. 178

Үүсгэн байгуулагчийн сургаал

## Өөд болсон ээждээ зориулах өргөл

Сүүний дэлгүүрийн бизнес хийнгээ сургаалыг түгээх үйлсэд хичээн шамдаж байсан үеийн минь явдал.

Насан өөд болсон ээжийн минь дурсгалыг хүндэтгэх өдөр 6 дугаар сарын 22-ны өдөр тохиодог бөгөөд тэр өдөр гэрийн маань ч амин өдөр тохиож байсан тул сар бүр “Энэ л өдөр онцгойлон хичээнгүйлж өргөл өргөө.” гэж боддог юм. Тэр л өдөр тэгэхээс тэг гэсэн юм шиг энэ тэр сүсэгтэнд дуудагдсаар харанхуй шөнө болтол явах хэрэгтэй болдог билээ.

Ачлалт багш Араид энэ тухайгаа ярьтал, “Нивано, зөвхөн судар унших нь өргөл биш юм

шүү дээ. Зовсон нэгнийг аврахын төлөө ингэж уригдаж залагдаж явах чинь л илүү чухал. Ээж болон өвөг дээдэс тань хичнээн их тайтгарч, талархаж байгаа бол!” гэсэн юм. Цагаан Лянхуа Судрыг өөрийн биеэр унших өргөл гэдэг нь энэ юм байна гэдгийг тэр үед Араи багшаараа заалгаж авсан.

Тэр мөчөөс хойш өдөр бүр амрах ч чөлөөгүй бусдын сайн сайхны төлөө хичээсээр явахад, ээжийн минь аз жаргалтай царай нүдний өмнө үзэгдэх шиг л санагддаг болсон.

«Үүсгэн байгуулагчийн үг 9» X224-225

Living the Lotus  
Vol. 178 (2020.07)

**Хэвлэсэн:** Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

**Хаяг:** Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

**TEL:** +81-3-5341-1124

**FAX:** +81-3-5341-1224

**Email:** living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

**Ахлах редактор:** Саитоо Коичироо

**Орчуулсан:** Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа

**Эхийг хянасан:** Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## Яг одоо чадах зүйлээ хийцгээе



Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Бодисадва хүн юуг зорьж, юуг тангараглах вэ?

Шүлэг найрагч Ийда Дакоцу гуайн “Сүсэг бишрэлт эхээ дурсахуй, ай Үрабонь өдөр” хэмээх шүлэг байдаг. Японд 7 сард өвөг дээдэстээ талархах Үрабон ёслол болдог боловч энэ жил гэр бүлээрээ цуглан нийгэмлэг, сүм хийддээ мөргөхөд хэцүү нөхцөл байдалтай байна.

Бурханлаг сэтгэл гэдэг “Хамаг амьтныг аврах сэтгэл” учраас бид бүхэн одоо дэлхий даяар тархаад буй өвчнөөс болж зовж байгаа хүмүүст сэтгэл зүрхээ зориулан, байдал хурдан хэвийн болохыг хүсэн залбирсаар байна. Хүн бүр өөрийнхөө юу чадахыг бодож, түүнийгээ өдөр тутам хичээнгүйлэн хэрэгжүүлбэл зохилтой хэмээн бодно.

Ингээд бодохоор эх газраас гэнэт хөөрөн гарч ирж, энэ замбуутивд бурханы сургаалыг түгээн хэрэгжүүлж “Бүх хүнийг аварна.” хэмээн тангарагласан хэмжээлшгүй тоот бодисадва нар санаанд орж байна.

Цагаан Лянхуа Судрын “Газар доороос гарсныг өгүүлэх бүлэг”-т тэдгээр “Газраас хөөрөн гарч ирсэн бодисадва нар”-ын төлөөлөл болсон Дээд явдалт, Хязгаарлашгүй явдалт, Ариун явдалт, Амгалан явдалт хэмээх дөрвөн бодисадва нар гардаг. Эдгээр бодисадва нар нь бурханы зам мөрөөр явагч хүн хамгийн түрүүнд “Бурхан шиг болох юмсан.” хэмээн залбирахад, өөрөөр хэлбэл бодь сэтгэлийг үүсгэхдээ тангарагладаг “Бодисадвагийн дөрвөн агуу тангараг-ын бэлгэ тэмдэг юм.

*Дээд Явдалт Бодисадва:* Бурханы зам мөр оройгүй дээд байлаа ч гарцаагүй төгс эзэмшинэ.

*Хязгаарлашгүй Явдалт Бодисадва:* Бурханы сургаал хязгааргүй байлаа ч гарцаагүй бүгдийг суралцна.

*Ариун Явдалт Бодисадва:* Шунал хүсэл тоо томшгүй байлаа ч гарцаагүй бүгдээс нь ангижирна.

*Амгалан Явдалт Бодисадва:* Хамаг амьт ан хязгааргүй олон байлаа ч гарцаагүй бүгдийг нь авран нигүүлсэнэ.

Энэхүү дөрвөн тангарагыг амьдралдаа тохируулан, өдөр тутамдаа хэрхэн хэрэгжүүлбэл зохилтойг мэдэхгүй байгаа нэгэн ч бий байх. Бурханы сургаалыг маш ойлгомжтойгоор сургасан Зэн Буддизмын багш Мацүбара Тайдоо “Бодисадвагийн дөрвөн агуу тангараг”-ыг амьдралын хамгийн бодитой сургаал хэмээгээд, дараагийн адилаар тайлбарласан байна.



Бурханы зам мөрийг төгс эзэмших тангараг: Төгсөшгүй зам мөрөөр алгуур алгуурханаар ахих.

Бурханы сургаалыг сурч гүйцээх тангараг: Өдөр бүр нэг сургаал сурах.

Шунал хүслээс бүрэн ангижирах тангараг: Хөл доороо байгаа хогоо түүх.

Хамаг амьтан бүхнийг аврах тангараг: Ойр дотны хүмүүсийнхээ төлөө зүтгэх (өглөг өгөх).

Та бүхэн одоо, бурханы зам мөрөөр явж буй бодисадва хүн болохынхоо хувьд юуг зорьж, юуг тангараглаж өдөр бүрийг өнгөрүүлж байгаа вэ?

### Одоо л “Суралцах” боломж

“Бодисадвагийн дөрвөн агуу тангараг”-д тулгуурлан өөрийнхөө одоо юу чадахыг бодож буй хүн бол яах аргагүй бурханы сургаалд итгэж, түүнийгээ хэрэгжүүлэгч итгэл сэтгэлтэй хүн ба тэр нь бурхантай адил зүрх сэтгэлтэй болж буй хэрэг юм. “Тийм гэж үү” хэмээн эргэлзэх нэгэн байж магадгүй ч, сургаалтай учирснаар “Бурхан шиг болох юмсан.” гэсэн сэтгэл төрөх юм бол бид хэдийн бурхантай адил сэтгэл зүрхтэй болжээ гэсэн үг.

Бурхан ба бид бүхэн “Салшгүй нэгэн цогц” гэдэг. Жирийн хүн ч бай, гэгээнтэн хүн ч бай тэдгээрийн үндсэн мөн чанар нь адил гэсэн утгаар “Энгийн хүн ч, гэгээнтэн хүн ч эрх тэгш.” гэдэг үг бий. Бид бурханы сургаалын эрхэм нандин чанарыг ойлгож буй нь түүний уг үндэст орших “Бүх хүнийг аврах юмсан.” гэсэн гайхамшигтай хүсэл зорилго танд ч бас байгаа учраас тэр билээ. Хүний төрлийг олно гэдэг нь бурхантай адил зүйл бидний дотор оршиж байна гэсэн үг. Үүнд итгэх нь сүсэг бишрэл бөгөөд итгэл үнэмшил гэж хэлж болно.

Тэр утгаараа одоо яг л өөрийн сүсэг бишрэл ямар хэмжээнд байгааг эргэн харж, сургаалыг өдөр дутамдаа хэрэгжүүлэх гэсэн “Сургаал номд суралцах” үйлээ дахин давтан хийж, бодисадва хүн болохоо илүү гүнзгий ухамсарлах сайхан боломж ч байж мэдэх юм.

“Газар доороос гарсныг өгүүлэх бүлэг”-т дээр өгүүлсэн дөрвөн бодисадва мэт хүнийг “Бүх хүн учрах юмсан гэж хүсэн мөрөөддөг хүмүүс” гэсэн байгаа юм.

Надад ч гэсэн тус нийгэмлэгийн ахмад гишүүд болон бусад шашныхан дотроос “Дахин уулзах юмсан” гэж бодогддог хүн бий. Тэд бурханыг үнэн сэтгэлээсээ хүндлэн дээдэлдэг, нөгөөтэйгүүр зовлон шаналалын ёроолд живсэн хүмүүст үргэлж санаа тавьж, анхаардаг, энэрэл хайр нь ундарч байдаг талаараа дээрх дөрвөн бодисадватай адилхан юм. Бид ч гэсэн тийм сэтгэлээ нээн гаргаж, өдөр бүр бурханы зам мөрд хичээн зүтгэвэл зохилтой.



# Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

## «Оройн Дээд Цагаан Лянхуа Судар» Түүнчлэн Ирсэний Насны Чинээг өгүүлэх 16 дугаар бүлэг (Сүүл хагас)

### Бурхан мөнх оршдог

Шагжамүни бурхан мэт гайхамшигтай удирдан чиглүүлэгч үргэлж ойр байж, сургаал айлдан, хүмүүсийг зөв замд чиглүүлдэг бол амьдралд санаа зовох зүйл байхгүй. Гэвч тийм удирдагч байхгүй болчихоор аажим аажмаар эргээд хэвэндээ ордог нь эгэл хүний гаслан гэлтэй. Зөвхөн нүдэнд үзэгдэх зүйлд л итгэдэг эгэл хүн Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Будда болох Бурхан байнга дэргэд нь байх атал, ил харагдаж байсан Бурхан багш (хүн болж төрсөн Шагжамүни бурхан) үгүй болчихоор нэг л мэдэхэд зам мөрөөс хазайх гээд байдаг.

Шагжамүни бурхан үүнд сэтгэл зовон “Бурхан бол үхэшгүй мөнх” болохыг сайтар зааж сургахын тулд дараах жишээг айлдсан. Хичнээн удирдан чиглүүлэгч байхгүй байсан ч, жинхэнэ үнэний сургаал нь байвал аз жаргалтай болж чадна гэдгийг уг үлгэрээр сургажээ.

Хүүхдүүд (хамаг амьтан) аав (Бурхан)-ынхаа эзгүйд андуурч хор уугаад, үхэх сэхэх дээрээ тулдаг. Энэ нь мундаг удирдагчаа байхгүй хооронд дур зоргоороо амьдарсны уршгаар зовж шаналсан гэсэн утгатай.

Тэр үед аав нь зорьсон газраасаа харьж ирдэг. Хор (таван хүсэл шуналдаа ороогдсон амьдрал)-оос болж ухаан балартсан хүүхдүүд нь аавыгаа хараад маш их баярлажээ. Учир нь хүн хэдий зам мөрөөс хазайсан ч гэсэн бурханлаг чанар нь байж л байдаг.

### Шашны талаарх явцуу ойлголт

Алдартай эмч аав нь өөрөөр хэлбэл Бурхан багш “Төөрөгдлийг хөөн зайлуулах эм”, “Жинхэнэ билиг оюуныг олж авах эм”, “Хүний төлөө гэсэн сэтгэлтэй болгодог эм” зэрэг янз бүрийн чухал нандин эмүүдийг найруулан, түүнийгээ эгэл жирийн хүнд уухад амар болгоод өгдөг. Энэ бол уран аргасын сургаал юм.

Түүнийг уусан хүмүүс шууд аврагдсан бол, хэрэг болгон найруулж өгсөн сайн эмийг ууя ч гэхгүй хүмүүс маш олон байв. Учир нь бодит байдал дээр үнэр, амт сайхан тэрхүү эм угийн хүнлэг сэтгэлээ гэсэн хүмүүсийн хувьд хачин

үнэртэй, муухай өнгөтэй харагддаг байна. Өөрөөр хэлбэл таван шунал хүсэлдээ живээд буй хүмүүсийн хувьд Бурхан багшийн сургаал яагаад ч юм яршиг түвэгтэй санагдаж, сургаалыг ухаарья гэж боддоггүй. Ийм л учиртай.



### Үгүйлэн санах мэдрэмж

Энэ бол маш ахар бодолтой хүний дур зоргоороо зан. Тиймээс Бурхан багш хүмүүсийн нүдийг нээх онцгой арга бодож олдог. Тэр нь харагдахгүй газарт нэг хэсэг нуугдах юм.

Түүхэн үүднээсээ Шагжамүни бурхан насан өөд болох гэсэн үг. Хэрэв тэгвэл хүмүүс гуныж гутарч, үгүй болсон агуу удирдан чиглүүлэгчээ туйлын ихээр үгүйлэн санах болно. Ам нь цангасан хүн ус уухыг хүсэхтэй адил үгүйлэх сэтгэл туйлын ихээр төрнө. Үүнийг сударт “Хотлоор хүсэмжлэн санах”, “Цангасан мэт хүсэхүй.” гэсэн байдаг.

Тийнхүү сэтгэл нь шимширэхээр хүн зайлшгүй жинхэнэ мөн чанараа эргэн олж авч, нүд нь нээгддэг байна. Одоо ямар нэг зүйл хийхгүй бол болохгүй юм байна хэмээн бодож, үлдээсэн сургаал (сайн эм) руу нь тэмүүлдэг учиртай.



“Ямар нэг зүйлийг хүсэмжлэх сэтгэл” нь зөвхөн хүн болж төрсөн бодит бурханд хандсан байх албагүй. Үүнийг хийсвэрээр бодоод үзвэл дараахын адил болно. Өдийг хүртэл бурхан, будда зэрэгт ямар ч сонирхолгүй, зөвхөн өдөр тутмын амьдралдаа хамаг анхаарлаа хандуулж байсан хүн ямар нэгэн бэрхшээлтэй нүүр тулгарсан үедээ хэн нэгнээс аврал эрж, эсвэл материаллаг амьдралдаа сэтгэл хангалуун байгаа боловч яагаад ч юм нэг л хоосон оргиж, сэтгэлийг нь дүүргэх зүйлийг хайх үедээ өөрийн мэдэлгүй Бурхан тэнгэрээс “надад туслаач”, “сэтгэлийг минь хуваалцаач” хэмээн хүсдэг.

Энэ мэтчилэн түүхэн Бурхан багш, хийсвэр Бурхан тэнгэр аль нь ч байсан хамаагүй, ямар ч байсан өөрийг нь жинхэнэ аз жаргалтд хүргэх зүйлийг цангасан хүн ус хүсэхтэй адил туйлын ихээр хүсч, үгүйлж байж тэр хүний сэтгэл ариусч, аз жаргалтай болдог. Шашин нь философи болон ёс суртахууны сургаалаас үүгээрээ ялгаатай юм. Мундаг философи болон ёс суртахууны сургаалыг толгойгоороо (өнгөн талдаа) “Аан, ийм учиртай юмсанж.” гэж ойлгодог. Бүх хүн түүнийг ойлгож, тэр дагуу биелүүлж чадвал асуудалгүй. Даанч бодит байдал огт тийм биш. “Өнгөн талдаа” ойлгоод байгаа ч, хүнд “Далд сэтгэл” хэмээх муу санаа, бодол байдаг бөгөөд тэр нь өөрийг нь анзаараа ч үгүй байхад төөрөгдүүлж, сайн бус үйлдэл хийлгэдэг. Тиймээс энэхүү “Далд сэтгэл” хүртэл ариусгахгүй бол хүн аврагдаж чадахгүй. Тэгвэл сэтгэлийн гүнээс авахуулаад өөрчилж өгдөг зүйл бол шашин хийгээд сүсэг бишрэл юм. Энэ нь уг бүлгийн нэгэн гол санаа болно.

### Нүдээ нээвэл Бурхан харагдна

Эдгээр хүүхдүүд ч гэсэн аавынхаа хайрыг үгүйлэн санасан их хүслийнхээ ачаар нүд нь нээгдсэн. Ингээд нүдээ нээн, жинхэнэ өөрийнхөө мөн чанарыг олж автал аав нь яах ийхийн зуургүй харьж ирдэг. Өөрөөр хэлбэл хүмүүс гэнэт нүд нь нээгдэн анзаарахад Бурхан үргэлж дэргэд нь байж байдаг... гэсэн утгатай.

Бурхан багш бол үхэшгүй мөнх бөгөөд бидний дэргэдээс хором ч холддоггүй. Үгүй ээ, “дэргэд” бус, Бурхан үргэлж бидний дотор ч, гадна ч бүрэн бүтнээрээ оршиж байдаг. Бид бүхэн Бурхантай нэгэн бүхэл билээ.

Тэгэхээр Бурхан устаж үгүй болно гэдэг нь бид түүнийг мартаж, анзаарахаа больчихдог гэсэн үг. Хүмүүс таван мэдрэхүйгээрээ бодитоор мэдрэгддэггүй зүйлийг хэзээд анхаардаггүй. Таван мэдрэхүйгээрээ мэдрдэг

зүйлийг хүртэл, жишээлбэл агаар, нар, ус гэсэн оршихуйг ч гэсэн ихэнхдээ мартсан байдаг. Харин ямар нэг зүйл тохиолдоход, ялангуяа тэр чухал оршихуй дутагдахад түүний хичнээн хэрэгтэй, талархууштай болохыг санадаг.

Бурханы хувьд ч гэсэн бид адилхан алдаа гаргадаг. Бурханы эх бие бол энэ ертөнцийн бүхий л оршихуй, аливаа бүхнийг амьдруулж буй Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Будда билээ. Тиймээс тэрхүү Язгуурын Бурханы хүсэл сэтгэл (хорвоогийн жам ёс)-ийн дагуу амьдрах юм бол сэтгэл зүрх эрх чөлөөтэй, аз жаргалтай байх байтал, нэг л мэдэхэд түүнийг мартчихдаг учраас дур зоргоороо үйлдэл хийж, түүнээсээ болж өөрөө өөрийгөө зовлонд унагадаг байна.

### Бурханы хүчээр амьдарч буйгаа ухаарах

Хэрэв бид үргэлж “Би Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Буддагийн ачаар амьдарч буй.” гэсэн гүн гүнзгий ухамсартай байж, “Ялж Төгс Нөгчсөн Язгуурын Буддагийн ачаар амьдарч байгаа болохоор түүний хүсэл сэтгэлийн дагуу амьдрах нь зөв амьдрал юм байна.” гэсэн товч бөгөөд тодорхой үнэнийг гэгээрч, Язгуурын Буддагийн орчлонгийн хуулинд тулгуурлан айлдсан Шагжамүни бурханы сургаалын дагуу амьдрах юм бол үргэлж өөртөө бат итгэлтэй амьдарч чадах ба амьдралын зовлон зүдгүүр зэрэгтэй учирлаа ч зовлон гэж боддоггүй болчихдог.

Хүний амьдрал угтаа ийм л байх учиртай ба уг бүлгээр хамгийн том чухал зүйл болгож



## Яг одоо чадах зүйлээ хийцгээе

Шинэ төрлийн корона вирус ингэж удаан үргэлжилнэ гэж бодсонгүй. Гэхдээ яг одоо “Амьдралын шинэ хэв маяг, шинэлэг өдөр”-ийг санаачлах цаг үе ирээд байна гэж бодож байна.

Бидний хувьд Цагаан лянхуа судрын сургаалыг нэг ч гэсэн хүнд дамжуулах хүсэл зорилготой билээ. Энэ сарын ерөнхийлөгчийн сургаалд “Яг одоо чадах зүйлээ хийцгээе” хэмээн сургасан байна.

Цагаан лянхуа судрын “Газар доороос хөөрөн гарч ирсэнийг үгүүлэх бүлэг”-ийн “Газраас хөөрөн гарч ирсэн бодисадва”-аар жишээ татан Бодисадвагийн дөрвөн агуу тангарагийн талаар айлдсан. Цаашлаад бодисадва болохынхоо хувьд юуг зорьж, ямар тангараг тавин өдөр бүрийг өнгөрүүлэх хэрэгтэй вэ хэмээн биднээс асуужээ.


Корона вирус нэг ч гэсэн өдрийн өмнө намжаасай, бүх хүмүүс аврагдаж, аз жаргалтай болоосой хэмээн залбирч, эхлээд өөрөө судрын сургаалыг дахин давтан сурч, бодисадва гэсэн ухамсараа батжуулан, өдөр бүр сургаалыг хэрэгжүүлье гэж бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга  
Саитоо Коичи





# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA  
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633  
Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

## Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA  
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

## Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA  
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA  
POBox 33636, CA 90033, USA  
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567  
Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA  
POBox 778, Pacifica, CA 94044, USA  
TEL: 1-650-359-6951 Email: [info@rksf.org](mailto:info@rksf.org)  
URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA  
TEL: 1-212-867-5677 Email: [rkny39@gmail.com](mailto:rkny39@gmail.com) URL: <http://rk-ny.org>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA  
TEL: 1-773-842-5654  
Email: [murakami4838@aol.com](mailto:murakami4838@aol.com) URL: <http://rkchi.org>

## Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA  
POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA  
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303  
Email: [rkokdc@gmail.com](mailto:rkokdc@gmail.com) URL: <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA  
TEL: 1-303-446-0792

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA  
URL: <http://www.rkina-dayton.com>

## The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA  
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437  
Email: [info@rkina.org](mailto:info@rkina.org) URL: <http://www.rkina.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA  
(Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA  
TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745  
Email: [dharmasanantonio@gmail.com](mailto:dharmasanantonio@gmail.com)  
URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

## Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA  
TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261  
Email: [rkseattlewashington@gmail.com](mailto:rkseattlewashington@gmail.com)  
URL: <http://buddhistlearningcenter.org>

## Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil  
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377  
Email: [risho@rkk.org.br](mailto:risho@rkk.org.br) URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>  
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

### Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

### 在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3  
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

### 在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F  
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

### 社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓  
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan  
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

### 台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號  
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan  
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488  
Email: kosekaitainan@gmail.com

### Risho Kosei-kai South Asia Division

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

### Risho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

### Risho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

### Risho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

### Risho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,  
Bihar, India

### Risho Kosei-kai of Patna Dharma Center

### Risho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,  
New Delhi 110060, India

### Risho Kosei-kai of Singapore

### Risho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,  
Phnom Penh, Cambodia

### RKISA Risho Kosei-kai International of South Asia

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

### Risho Kosei-kai of Bangkok

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairisho@gmail.com

### Risho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

### Risho Kosei-kai of Polonnaruwa

### Risho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
TEL/FAX: 880-31-626575

### Risho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,  
Bangladesh

### Risho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

### Risho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

### Risho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

### Risho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

### Risho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

### Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia  
TEL: 7-4242-77-05-14

### Risho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

### Risho Kosei-kai Friends in Shanghai

### Risho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia  
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

### Risho Kosei-kai of Erdenet

### Risho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia  
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

### Risho Kosei-kai of the UK

### Risho Kosei-kai of Paris

### Risho Kosei-kai of Venezia

### Risho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F  
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan  
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>